



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Ерөнхий боловсролын Говийн ирээдүй сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2026/109/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дундговь аймаг 2026 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Т.Батсайхан Утас: 70592225 Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn</p> <p>Аудитыг гүйцэтгэсэн: Азуре Хүлүг Аудит ХХК Утас: 70110090 Цахим хаяг: audit@azure.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
3.1 Төлбөрийн акт.....	8
3.2 Албан шаардлага	9
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	10

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

дод.Од.д/4

№

48

танай

-ны №

-т

ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
ГОВИЙН ИРЭЭДҮЙ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ О.ЭРДЭНЭТӨГС ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Сайнцагаан сумын ерөнхий боловсролын Говийн ирээдүй сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Сайнцагаан сумын ерөнхий боловсролын Говийн ирээдүй сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчийн үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 400,609.5 мянган төгрөгөөр өссөн байна. Мөн балансаас баланст хөрөнгө шилжүүлсэн авсантай холбоотой үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 14,286,754.9 мянган төгрөгөөр өсжээ. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй

4826050162

болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 65 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 84.4 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		/төгрөгөөр/	
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	108,251,104.78	37,862,592.30
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	108,251,104.78	37,862,592.30
31210	Төгрөг	108,251,104.78	37,862,592.30
31211	Төрийн сангийн харилцах	98,563,132.86	37,862,592.30
31218	Ахмадын сангийн харилцах	9,687,971.92	-
33	АВЛАГА	4,796,278.20	47,972.92
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,930,086.25	1.00
33101	Цалингийн авлага	272,278.00	-
33102	НДШ-ийн авлага	1,657,808.25	-
33106	НДС-аас авах авлага	-	1.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	47,971.92
33500	Бусад авлага	2,866,191.95	-
33520	Хувь хүмүүсээс авах авлага	2,866,191.95	-
35	БАРАА МАТЕРИАЛ	332,905,786.75	441,247,778.04
35100	Түүхий эд материал	138,054,122.78	173,131,989.07
35110	Тусгай зориулалттай материал	137,934,442.78	172,599,659.07
35130	Эм боох материал	119,680.00	532,330.00
35400	Хангамжийн материал	194,851,663.97	268,115,788.97
35410	Бичиг хэргийн материал	13,426,550.00	16,301,550.00
35420	Аж ахуйн материал	175,964,348.97	238,815,533.97
35450	Барилгын засварын материал	2,115,500.00	3,050,500.00
35460	Хүнсний материал	3,345,265.00	9,948,205.00
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	445,953,169.73	479,158,343.26
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,845,123,861.47	16,131,878,839.90
39200	Биет хөрөнгө	1,554,750,048.18	15,843,272,960.45
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,522,243,856.82	15,796,457,854.82
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(353,911,791.17)	(465,698,309.77)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	32,890,000.00	32,890,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(9,866,999.88)	(13,155,999.84)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	463,967,071.40	537,463,271.40
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(192,397,971.36)	(273,663,453.27)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	115,725,121.13	278,513,921.13
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(68,829,610.68)	(94,464,695.94)
39217	Номын фонд	44,930,371.92	44,930,371.92
39300	Биет бус хөрөнгө	290,373,813.29	288,605,879.45
39301	Программ хангамж	26,053,670.00	26,053,670.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Программ хангамж	(19,287,856.71)	(21,055,790.55)
39303	Бусад биет бус хөрөнгө	283,608,000.00	283,608,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	1,845,123,861.47	16,131,878,839.90
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	2,291,077,031.20	16,611,037,183.16
41	БОГИНО ХУГАЦААТ ОР ТӨЛБӨР	3,663,467.00	39,011,678.48
41300	Өглөг	3,663,467.00	39,011,678.48
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,963,467.00	5,570,750.00
413201	Бичиг хэргийн өглөг	-	2,664,000.00
413203	Түлш халаалтын өглөг	90.00	-
413208	Хоолны өглөг	2,963,377.00	2,345,250.00
413210	Урсгал засварын зардлын тооцоо	-	361,500.00
413213	Бусад зардлын өглөг	-	200,000.00
41360	Бусад өглөг	-	33,440,928.48
41361	Байгууллагад төлөх өглөг	-	33,440,928.48
4	НИЙТ ОР ТӨЛБӨР (IV)	3,663,467.00	39,011,678.48
51	Засгийн газрын хувь оролцоо	2,287,413,564.20	16,572,025,504.68
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,695,912,859.14	1,695,912,859.14
511001	Засгийн газрын оруулсан капитал засгийн газрын сан	1,695,912,859.14	1,695,912,859.14
51200	Хуримтлагдсан үр дүн	(442,394,893.55)	13,842,217,046.93

51210	Өмнөх үеийн үр дүн	(736,521,773.00)	(445,261,085.50)
51220	Тайлант үеийн үр дүн	294,126,879.45	14,287,478,132.43
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,033,895,598.61	1,033,895,598.61
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	2,287,413,564.20	16,572,025,504.68
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	2,291,077,031.20	16,611,037,183.16

2.2 Аудит хийсэн санхүү үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
13	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,386,040,200.00	4,158,805,600.00
1310	Улсын төсвөөс	2,996,312,700.00	3,403,836,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,996,312,700.00	3,403,836,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	389,727,500.00	754,968,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	389,727,500.00	754,968,700.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	401,424,702.98	14,605,195,400.74
1200	Нийтлэг татварын бус орлого	401,424,702.98	14,605,195,400.74
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	52,266,086.00	62,525,545.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	42,790,086.00	62,525,545.00
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	9,476,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	302,913,509.33	14,460,287,998.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал	46,245,107.65	82,381,857.74
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,787,464,902.98	18,764,001,000.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,470,266,311.97	4,476,522,868.31
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,276,473,285.92	4,138,757,823.72
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,300,238,529.74	2,700,848,038.89
210101	Үндсэн цалин	1,612,057,234.53	1,614,587,347.99
210102	Нэмэгдэл	565,171,885.21	893,309,650.35
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	-	84,542,276.38
210104	Урамшуулал	123,009,410.00	108,408,764.17
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	285,329,591.75	334,374,372.23
210201	Тэтгэврийн даатгал	193,493,691.75	228,670,752.31
210202	Тэтгэмжийн даатгал	22,959,000.00	26,757,854.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,479,500.00	13,378,727.47
210204	Ажилгүйдлийн даатгал	11,479,500.00	13,378,727.47
210205	Эрүүл мэндийн даатгал	45,917,900.00	52,188,310.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	241,699,526.95	586,975,283.41
210301	Гэрэл, цахилгаан	22,521,995.95	52,228,508.59
210302	Түлш, халаалт	179,426,253.00	488,250,674.00
210303	Цэвэр, бохир ус	39,751,278.00	46,496,100.82
2104	Хангамж, бараа материалын зардал	35,699,747.56	45,136,041.45
210401	Бичиг хэрэг	21,224,870.00	13,366,400.00
210402	Тээвэр, шатахуун	5,182,609.00	3,646,350.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,292,268.56	10,503,310.00
210408	Бараа материал акталсны зардал	-	17,619,981.45
2105	Нормативд зардал	80,205,090.30	118,821,904.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	324,450.00	194,250.00
210502	Хоол, хүнс	79,880,640.30	118,627,654.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	52,051,650.00	25,238,400.00
210604	Урсгал засвар	52,051,650.00	25,238,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,059,588.18	39,214,348.69
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	19,059,588.18	39,214,348.69
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	262,189,561.44	288,149,435.05
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	100,194,474.33	64,405,415.48
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	700,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	161,295,087.11	223,744,019.57
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	193,793,026.05	337,765,044.59
2132	Бусад урсгал шилжүүлэг	127,687,513.00	201,363,618.00

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	127,687,513.00	201,363,618.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	66,105,513.05	136,401,426.59
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	66,105,513.05	136,401,426.59
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	3,470,266,311.97	4,476,522,868.31
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	317,198,591.01	14,287,478,132.43
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	23,071,711.56	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	23,071,711.56	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	23,071,711.56	-
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	294,126,879.45	14,287,478,132.43

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он /төгрөгөөр/
13	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,386,040,200.00	4,158,805,600.00
1310	Улсын төсвөөс	2,996,312,700.00	3,403,836,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,996,312,700.00	3,403,836,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	389,727,500.00	754,968,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	389,727,500.00	754,968,700.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	52,266,086.00	62,525,545.00
1200	Нийтлэг татварын бус орлого	52,266,086.00	62,525,545.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	52,266,086.00	62,525,545.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	42,790,086.00	62,525,545.00
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	9,476,000.00	-
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,438,306,286.00	4,221,331,145.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,350,927,658.10	4,241,508,657.48
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,186,421,072.05	3,947,054,590.97
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,295,840,781.23	2,700,848,038.89
210101	Үндсэн цалин	1,515,964,149.03	1,614,587,347.99
210102	Нэмэгдэл	657,545,250.39	893,309,650.35
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	-	84,542,276.38
210104	Урамшуулал	122,331,381.81	108,408,764.17
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	286,987,398.86	333,144,286.98
210201	Тэтгэврийн даатгал	195,151,498.86	227,440,667.06
210202	Тэтгэмжийн даатгал	22,959,000.00	26,757,854.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,479,500.00	13,378,727.47
210204	Ажилгүйдлийн даатгал	11,479,500.00	13,378,727.47
210205	Эрүүл мэндийн даатгал	45,917,900.00	52,188,310.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	272,002,036.95	586,975,373.41
210301	Гэрэл, цахилгаан	22,521,995.95	52,228,508.59
210302	Тулш, халаалт	210,008,163.00	488,250,764.00
210303	Цэвэр, бохир ус	39,471,878.00	46,496,100.82
2105	Нормативд зардал	77,512,125.30	113,997,974.00
210502	Хоол, хүнс	77,512,125.30	113,997,974.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	51,619,950.00	34,411,900.00
210604	Урсгал засвар	51,619,950.00	34,411,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,222,918.04	43,223,848.69
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	49,222,918.04	43,223,848.69
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	153,235,861.67	134,453,169.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	133,262,011.67	124,834,769.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	19,973,850.00	9,618,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	164,506,586.05	294,454,066.51
2132	Бусад урсгал шилжүүлэг	98,401,073.00	158,004,668.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	98,401,073.00	158,004,668.00

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	66,105,513.05	136,401,426.59
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	66,105,513.05	136,401,426.59
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	47,971.92
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	47,971.92
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	3,350,927,658.10	4,241,508,657.48
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	87,378,627.90	(20,177,512.48)
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	25,030,000.00	50,211,000.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	25,030,000.00	50,211,000.00
2251	Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн	25,030,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	25,030,000.00	50,211,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	25,030,000.00	50,211,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	(25,030,000.00)	(50,211,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	62,348,627.90	(70,388,512.48)
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	45,902,478.02	108,251,104.78
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	108,251,105.92	37,862,592.30

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	/төгрөгөөр/
				Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,695,912,859.14	1,033,895,598.61	(736,521,773.00)	1,993,286,684.75
Тайлант үеийн үр дүн	-	-	294,126,879.45	294,126,879.45
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,695,912,859.14	1,033,895,598.61	(442,394,893.55)	2,287,413,564.20
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(2,866,191.95)	(2,866,191.95)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,695,912,859.14	1,033,895,598.61	(445,261,085.50)	2,284,547,372.25
Тайлант үеийн үр дүн	-	-	14,287,478,132.43	14,287,478,132.43
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,695,912,859.14	1,033,895,598.61	13,842,217,046.93	16,572,025,504.68

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Татаас, санхүүжилтийн орлого	4,417,759,000.00	4,158,805,600.00	258,953,400.00
Улсын төсвөөс	3,543,588,000.00	3,403,836,900.00	139,751,100.00
Орон нутгийн төсвөөс	754,968,700.00	692,443,155.00	62,525,545.00
Тусламжийн орлого	119,202,300.00	62,525,545.00	56,676,755.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,417,759,000.00	4,158,805,600.00	258,953,400.00
Ажиллагчидтай холбогдсон зардал	3,085,138,100.00	3,033,992,325.87	51,145,774.13
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,742,345,000.00	2,700,848,038.89	41,496,961.11
Цалин	2,742,345,000.00	2,700,848,038.89	41,496,961.11
Нийгмийн хамгааллын шимтгэл	342,793,100.00	333,144,286.98	9,648,813.02
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	342,793,100.00	333,144,286.98	9,648,813.02
Бараа, дүйлчилгээний урсгал зардал	1,332,620,900.00	1,185,513,814.69	147,107,085.31

Тогтмол зардал	720,534,700.00	586,975,373.41	133,559,326.59
Гэрэл цахилгааны зардал	52,400,000.00	52,228,508.59	171,491.41
Түлш, халаалтын зардал	622,934,700.00	488,250,764.00	134,683,936.00
Цэвэр, бохир усны зардал	45,200,000.00	46,496,100.82	(1,296,100.82)
Хоол	119,548,200.00	113,997,974.00	5,550,226.00
Бусад бараа үйлчилгээний зардал	218,274,400.00	198,830,750.59	19,443,649.41
Шуудан холбооны зардал	45,205,300.00	28,283,848.69	16,921,451.31
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	14,832,800.00	14,798,300.00	34,500.00
Урсгал засварын зардал	34,434,000.00	34,411,900.00	22,100.00
Бусад /үдийн цай/	179,791,500.00	158,004,668.00	21,786,832.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	-	50,211,000.00	(50,211,000.00)
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	4,417,759,000.00	4,219,506,140.56	198,252,859.44
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		98,563,132.86	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		37,862,592.30	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9,451.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс авлагатай холбоотой 7,101.7 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 2,349.6 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлээ.

3.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт 1: Нягтлан бодогч, нярав нарын ажлыг улирал бүр дүгнэж үр дүнгийн урамшуулал олгосон боловч тус сургуулийн захирлын 2025 оны А/33 тоот тушаалаар 2024 оны санхүүгийн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн үнэн зөв гаргаж, зөрчилгүй санал дүгнэлт авсан гэх үндэслэлээр хоёр сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 6,641.7 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-т "*улирлын ажлын дүнгээр мөнгөн урамшуулал олгох*", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "*Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлийг хориглоно,*" 15.1.3-т "*хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагналыг, урамшуулал, дэмжлэг олгох*", 15.2.6-д "*байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох*", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид олгох мөнгөн урамшуулал олгох журмын 2.2-т "*Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна*" гэж заасныг мөн үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна;

Шийдвэрлэсэн нь: Урамшуулал давхардуулан олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

Илрүүлэлт 2: Түрээсийн орлогыг орон нутгийн төсөвт 460.0 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 "*Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ,*" 41.2.1 "*хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх*", Дундговь аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 15 дугаар тогтоолын хавсралтын 1.7 "*Технологийн болон үйл ажиллагааны үндсэн чиглэлээс бусад зориулалтаар байр талбайг бусдад эзэмшүүлж ашиглуулахад түрээсийн гэрээ байгуулж түрээсийн орлогоос 40 хувийг орон нутгийн орлогод төвлөрүүлж байна*", 1.8 "*Түрээсийн орлогоос орон нутгийн төсөвт төвлөрүүлэх хэмжээг нийт орлогын 40 (дөр) хувиар тооцож түрээслэгч төсөвт төвлөрүүлнэ*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "*аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах*" гэж заасныг мөн үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна;

Шийдвэрлэсэн нь: Түрээсийн орлогыг орон нутгийн дансанд бүрэн төвлөрүүлээгүйд төлбөрийн акт тогтоосон

3.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Нийгмийн даатгалын тайланд 3 ажилтны нийгмийн даатгал төлөгчийн кодыг алдаатай тайлагнаснаас шалтгаалан 352.6 мянган төгрөгийн зардлыг буруу тайлагнасан байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хууль 16 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан *даатгуулагчийн шимтгэл төлөх тооцоог тухайн аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодогч, мөн зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн шимтгэл төлөх тооцоог нийгмийн даатгалын байгууллагын ажилтан гүйцэтгэнэ*" гэж заасныг мөн үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилтны нийгмийн даатгал төлөгчийн кодыг буруу тайлагнасан зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт 2: Шалгагдагч этгээд нь 2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр төрийн аудитын байгууллагад санхүүгийн тайлангаа хүргүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд 8.9.1 "*төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх*, 16 дугаар зүйлийн 16.5.7 "*байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах*" гэж заасныг мөн үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулийн хугацаанд санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланг хүргүүлээгүй зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт 3: Сургуулийн хүнсний материалын тайлангаас зарлагын баримт, хоолны ордерыг тулгаж шалгахад хоолны ордерт хүүхдийн тоо, өдрийн нормыг тэмдэглээгүй, Дотуур байрны хүүхдийн хоолыг Засгийн газрын тогтоолд зааснаас илүү дүнгээр зарцуулсан зэрэг зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*", 13.6 "*Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна*", 20 дугаар зүйлийн 20.2.5 "*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*", Засгийн газрын 2025 оны 254 дугаар тогтоол 2 "*Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдрах дунд болон ахлах ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6300 (зургаан мянга гурван зуу) төгрөгөөр, бага ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6000 (зургаан мянга) төгрөгөөр тус тус тогтоосугай*" гэж заасныг мөн үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дотуур байрны хоолны нормыг хэтрүүлэхгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 100 хувийг залруулагдаагүй зөрчил эзэлж байна. Нийт 9,451.3 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь санхүүгийн тайлангийн аудитын зөрчил байна. Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 9,451.3 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс 35,313.9 мянган төгрөгөөр бага байгаа тул "ӨӨРЧЛӨЛТГҮЙ" дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нягтлан бодогч, нярав нарын ажлыг улирал бүр дүгнэж үр дүнгийн урамшуулал олгосон боловч тус сургуулийн захирлын 2025 оны А/33 тоот тушаалаар 2024 оны санхүүгийн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн үнэн зөв гаргаж, зөрчилгүй санал дүгнэлт авсан гэх үндэслэлээр хоёр сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшууллыг давхардуулан олгосон байна.	1	6,641.7	1	6,641.7	-	-	-	-	-	-
Нийгмийн даатгалын тайланг цалингийн тооцоололтой тулган шалгахад 3 ажилтны нийгмийн даатгал төлөгчийн кодыг буруу тайлагнаснаас шалтгаалан цалингийн тооцоололд зөрүү үүссэн байна.	1	352.6	-	-	1	352.6	-	-	-	-
Сургуулийн хүнсний материалын тайлангаас зарлагын баримт, хоолны ордерыг тулгаж шалгахад хоолны ордерт хүүхдийн тоо, өдрийн нормыг тэмдэглээгүй, дотуур байрны хүүхдийн хоолыг Засгийн газрын тогтоолд зааснаас илүү дүнгээр зарцуулсан зэрэг зөрчил илэрлээ.	1	1,996.9	-	-	1	1,996.9	-	-	-	-
Түрээсийн орлогыг орон нутгийн төсөвт дугуу төвлөрүүлсэн байна.	1	460.0	1	460.0	-	-	-	-	-	-
Дүн	4	9,451.3	2	7,101.7	2	2,349.5	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шалгагдагч этгээд нь 2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр төрийн аудитын байгууллагад санхүүгийн тайлангаа хүргүүлсэн байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-	-
Дүн	1	-	-	-	1	-	-	-	-	-	-